



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Утас: 99019800 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn
----------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024-03-19 № 1/114
танай 2024-02-29 -ны № 1/80 -т

БУЛГАН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ Ж.ДАМДИНБАЗАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсөвт байгууллага, 2 тусгай сан, 1 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв, насан туршийн боловсрол төв зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Булган сумын 2023 оны төсвийн орлогыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолоор татвар, татварын бус орлогыг 1,076,832.8 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,376,200.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 299,367.2 мянган төгрөгөөр буюу 27.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бизнес хөгжлийн төв, Баян судал багт 150 хүүхдийн багтаамжтай Хүүхдийн цэцэрлэгийн барилга баригдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 03 тоот тогтоолоор "сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2023 оны хэрэгжилтийг 94.2 хувь буюу "хангалттай" гэж дүгнэжээ.

Монгол улсын баруун хил дээр 1948 онд болсон зэвсэгт тулгаралт дууссаны 75 жилийн ойг Булган суманд тэмдэглэн өнгөрүүлэх тухай Засгийн газрын 2023 оны 143 дугаар

тогтоол батлагдаж 2023 оны 06 дугаар сарын 08,09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР.



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	734,575.1	1,087,946.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	101,794.6	473,910.5
33	АВЛАГА	580,092.4	576,239.2
35	БАРАА МАТЕРИАЛ	52,688.1	27,797.1
36	НӨӨЦИЙН БАРАА	-	10,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,109,463.8	6,427,233.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,109,463.8	6,427,233.4
39200	Биет хөрөнгө	5,867,300.5	6,185,460.8
39300	Биет бус хөрөнгө	242,163.3	241,772.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,844,039.0	7,515,180.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	41,861.8	3,363.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41,861.8	3,363.4
41300	Өглөг	41,861.8	3,363.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,802,177.2	7,511,816.9
51	Засгийн газрын хувь оролцоо	6,802,177.2	7,511,816.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,313,277.7	1,313,277.7
51200	Хуримтлагдсан үр дүн	5,142,010.5	5,851,650.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	346,889.0	346,889.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,844,039.0	7,515,180.2

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,934,935.40	4,876,314.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	860,711.20	1,267,085.90
110	Орлогын албан татвар	726,430.40	1,101,392.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	726,430.40	1,167,964.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(66,571.60)
113	Хөрөнгийн албан татвар	83,368.90	60,483.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	50,911.90	105,209.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,015,973.80	969,485.80
120	Нийтлэг татварын бус орлого	1,015,973.80	969,485.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,058,250.40	2,639,742.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,564,354.20	4,166,674.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,564,354.20	4,166,674.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,206,702.30	4,144,852.10

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	669,146.90	636,796.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,400.70	79,479.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	303,559.30	120,307.50
2104	Хангамж, бараа материалын зардал	1,297,970.00	2,082,186.30
2105	Нормативт зардал	16,935.40	7,629.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,546.30	16,118.70
2107	Томилолт, зочны зардал	11,967.70	14,385.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,352.10	405,686.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	767,823.90	782,262.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,357,651.90	21,822.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	370,581.20	709,639.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,207,421.20	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(7,836,839.90)	709,639.70

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,258,509.70	4,337,168.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	860,711.20	1,267,085.90
110	Орлогын албан татвар	726,430.40	1,101,392.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	726,430.40	1,167,964.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(66,571.60)
113	Хөрөнгийн албан татвар	83,368.90	60,483.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	50,911.90	105,209.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	29,987.20	33,469.70
1181	Газрын төлбөр	11,377.80	62,032.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,546.90	9,708.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	319,498.80	430,340.00
120	Нийтлэг татварын бус орлого	319,498.80	430,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,078,299.60	2,639,742.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,197,172.70	1,710,297.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,197,172.70	1,710,297.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,712,912.80	1,685,998.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,759.40	698,482.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,443.50	97,875.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	313,706.00	85,071.30
2104	Хангамж, бараа материалын зардал	82,720.30	73,667.10
2105	Нормативт зардал	768.30	1,091.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,713.30	2,714.40

2107	Томилолт, зочны зардал	16,207.20	14,729.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,988.20	472,378.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,606.60	239,989.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,484,259.80	24,299.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,061,337.00	2,626,870.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,001,686.20	2,140,160.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,001,686.20	2,140,160.40
2200	Дотоод эх үүсвэрээр	1,001,686.20	2,140,160.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,001,686.20)	(2,140,160.40)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(257,100.00)	(114,594.40)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	257,100.00	114,594.40
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(197,449.20)	372,115.90
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	299,243.80	101,794.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	101,794.60	473,910.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,439,254.86	3,974,439.46	6,225,907.07	14,639,601.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,125,977.19)	(3,627,550.51)	6,752,943.40	(584.31)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,313,277.67	346,888.95	12,978,850.46	14,639,017.09
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,836,839.93)	(7,836,839.93)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,313,277.67	346,888.95	5,142,010.53	6,802,177.16
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,313,277.67	346,888.95	5,142,010.53	6,802,177.16
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,313,277.67	346,888.95	5,142,010.53	6,802,177.16
19	Тайлант үеийн үр дүн	-	-	709,639.71	709,639.71
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,313,277.67	346,888.95	5,851,650.25	7,511,816.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,600,492.20	3,549,967.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,049.50	1,352,541.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,360,744.30	1,328,242.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	657,923.20	637,324.51
210101	Үндсэн цалин	362,019.30	353,080.77
210102	Нэмэгдэл	182,555.00	169,441.71
210104	Урамшуулал	14,044.00	44,862.02
210105	Гэрээт ажлын хөлс	99,304.90	69,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,240.20	81,577.80
210201	Тэтгэврийн даатгал	55,923.40	55,424.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,579.20	6,520.30
210203	ҮОМШӨний даатгал	5,263.30	5,189.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,315.90	1,402.40
210205	Эрүүл мэндийн даатгал	13,158.40	13,041.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	477,384.00	472,094.83
210301	Гэрэл, цахилгаан	54,913.60	47,529.35
210302	Түлш, халаалт	417,470.40	423,545.48
210303	Цэвэр, бохир ус	5,000.00	1,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,631.60	34,626.60
210401	Бичиг хэрэг	3,509.90	4,292.00
210402	Тээвэр, шатахуун	26,604.90	26,233.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,266.80	3,851.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250.00	250.00
2105	Нормативт зардал	1,091.20	1,091.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,091.20	1,091.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,346.00	12,346.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.60	280.60
210604	Урсгал засвар	12,065.40	12,065.40
2107	Томилолт, зочны зардал	12,208.00	11,691.10
210702	Дотоод албан томилолт	12,208.00	11,691.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,125.80	43,696.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,883.30	41,678.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	460.00	430.18
210803	Даатгалын үйлчилгээ	290.00	290.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255.00	255.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.00	30.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,042.50	1,012.50
210807	Газрын төлбөр	165.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,794.30	33,793.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,572.50	31,572.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,221.80	2,221.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,305.20	24,299.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,305.20	24,299.20

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,525.70	16,525.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,779.50	7,773.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,100,842.70	2,082,832.10
220001	Барилга байгууламж	179,200.00	171,249.40
221001	Их засвар	1,639,322.40	1,637,595.80
222001	Тоног төхөөрөмж	161,320.30	153,222.90
223001	Бусад хөрөнгө	121,000.00	120,764.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	114,600.00	114,594.45
230001	Эргэж төлөгдөх зээл	114,600.00	114,594.45
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,600,492.20	3,615,533.19
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,474,492.20	3,428,009.01
320001	Орон нутгийн төсвөөс	1,489,649.50	1,443,166.31
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,984,842.70	1,984,842.70
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	126,000.00	187,524.17
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,400.00	9,375.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.00	178,149.17
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	54,600.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	54,635.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	120,201.28
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	85	85
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3
610001	Төсвийн байгууллага	3	3
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	41	41
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12
620003	Үйлчлэх ажилтан	7	7
620004	Гэрээт ажилтан	11	11
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41	41
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16
650010	Гэрээт ажилтан	5	5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	401,279.63	276,223.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,279.63	276,223.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,299.01	273,014.18
2104	Хангамж, бараа материалын зардал	-	7,004.65
210402	Тээвэр, шатахуун	-	7,004.65
2107	Томилолт, зочны зардал	3,589.55	2,486.00
210702	Дотоод албан томилолт	3,589.55	2,486.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	390,709.46	263,523.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	390,709.46	263,523.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,209.43

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,980.62	3,209.43
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,980.62	3,209.43
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	401,279.62	276,223.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	401,279.62	276,223.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	358,176.74	28,682.87
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,400.10	207,864.92
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,988.40	15,635.20
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	714.38	24,040.62

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 233,081.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулан 4,593.6 мянган төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмж өглөө. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг хүлээн аваагүй 124,649.8 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй,
- Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд 300.0 мянган төгрөгөөр өглөг тусгаагүй,
- ЗДТГ-ын тайланд ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан 1,174.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 10,000.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй орхигдуулсан,
- Санхүүгийн орлого үр дүнгийн тайланд 8,140.4 мянган төгрөгийн орлогыг дутуу,
- ТТЗ-ийн тайланд 8,140.4 мянган төгрөгөөр авлага дутуу,
- Тайлант үеийн үр дүнг 80,675.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 4,593.6 мянган төгрөгийн 3 заалт зөвлөмж өглөө.

3.1 Зөвлөмж

3.1.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтний зээлдэгч бүрээр тооцсон авлагын тооцоо, сангийн үйл ажиллагааны программ дахь авлагын үлдэгдэл хоорондоо зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Өгсөн зөвлөмж: Зээлийн эргэн төлөлтийн тооцоог зээлдэгч бүрээр дахин хийж авлагыг зөв тооцох

3.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөвт байгууллагуудын цэвэр бохир усны шугам сүлжээний ажил хийгдэж байгууллагуудын данс бүртгэлд тусгаагүй, Сумын төсөвт байгууллагуудын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэхдээ нэгтгэн тендер зарлаагүй шугам сүлжээний байгууллага бүрээр тус тусад нь гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.5-д "энэ хуулийн 8.1 дэх хэсэгт босго үнэнд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн мөрдөөгүй,

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар шийдвэр гаргуулан данс бүртгэлд тусгах, худалдан авах ажиллагааг холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулах

3.1.3 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ЗДТГ-ын 2023 оны төсвөөс Булган сум дахь Сум дундын шүүхийн 2022 оны 15/ШШ2022/00089 дүгээр шийдвэрээр Гэр бүл хүүхэд залуучуудын мэргэжилтэнд цалингийн шатлал буруулан олгосон холбоотой зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д заасан заалтын дагуу шийдвэрлэх

Дөрөв. Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	-	-										
ЗДТГ	-	-										
Спорт цогцолбор	2	1,904.6			2	1,904.6	2	1,904.6				
Булган хот тохижилт	2	43,594.1	2	43,594.1			2	43,594.1				
Хоршоо хөгжүүлэх сан	3	16,280.9	1	300.0	2	15,980.9	3	16,280.9				
ОНХС	2	186,310.2			2	186,310.2	2	186,310.2				
ТТЗ	4	30,490.0	3	19,315.2	1	11,174.8	4	30,490.0				
Дүн	13	278,579.8	6	63,209.3	7	215,370.5	13	278,579.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	673.8	1	673.8			1	1,609.9	-	-	-	-
ЗДТГ	6	1,791.7	2	1,791.7			4	10,108.9				
Спорт цогцолбор												
Булган хот тохижилт												
Хоршоо хөгжүүлэх сан	1	-					1					
ОНХС	1	-					1					
ТТЗ	1	-					1	4,593.6				
Дүн	11	2,465.5	3	2,465.5	-	-	8	16,312.4	-	-	-	-

Тав. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	байгууллагын нэр	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ИТХ	1		1					
2	ЗДТГ	1		1					
3	Спорт цогцолбор	1		1					
4	Булган хот тохижилт	1		1					
5	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
6	ОНХС	1		1	-		-		-
НИЙТ		6	-	6	-	-	-	-	-